

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/196/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)  
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал, аудитор Б.Мядагмаа  
Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaa@yahoo.com](mailto:b_myadagmaa@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/127  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ  
ЭРДМИЙН ДАЛАЙ ЦОГЦОЛБОР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ О.БАДРАА  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 50,049.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг төлөвлөж, 93.3 хувьтай дүгнэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх

үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>247,147,807.34</b>	<b>360,744,415.34</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	50,049,269.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	50,049,269.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	50,049,269.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	247,147,807.34	310,695,146.34
35110	Тусгай зориулалттай материал	40,010,941.50	36,997,284.50
35130	Эм боох материал	29,129,941.50	29,129,941.50
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		
35420	Аж ахуйн материал	207,136,865.84	273,697,861.84
35450	Барилгын засварын материал	76,313,165.76	78,235,121.76
35470	Бусад хангамжийн материал	2,320,000.00	8,345,000.00
		127,183,700.08	187,117,740.08
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,611,521,905.66</b>	<b>1,756,442,912.43</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,611,521,905.66	1,756,442,912.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,109,345,049.70	1,255,958,177.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,243,027,287.00	1,243,027,287.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-666,715,598.36	-695,327,276.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	323,741,978.45	616,022,870.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,046,027.41	-211,103,465.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	207,615,255.00	265,404,405.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,470,365.94	-125,296,169.23
39214	Бусад үндсэн хөрөнгө	91,835,784.50	91,835,784.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-40,253,778.92	-46,564,170.60
39217	Ном	107,610,515.38	117,958,912.38
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	502,176,855.96	500,484,735.00
39301	Програм хангамж	9,210,605.00	9,210,605.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,933,749.04	-4,925,870.00
39303	Бусад биет бус хөрөнгө	495,900,000.00	496,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,858,669,713.00</b>	<b>2,117,187,327.77</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,858,669,713.00</b>	<b>2,117,187,327.77</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,858,669,713.00	2,117,187,327.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн	1,159,968,168.00	1,160,268,168.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	-100,775,165.43	157,442,449.34
51220	Тайлант үеийн үр дүн	-100,775,165.43	-100,775,165.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	258,217,614.77
		799,476,710.43	799,476,710.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,858,669,713.00</b>	<b>2,117,187,327.77</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,061,677,119.79</b>	<b>4,214,153,577.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>284,456,805.34</b>	<b>351,110,077.90</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	284,456,805.34	351,110,077.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,206,550.00	50,050,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,335,000.00

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	250,250,255.34	299,725,077.90
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>461,370,714.45</b>	<b>3,863,043,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	3,358,187,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	3,358,187,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	40,566,514.45	6,251,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,787,114.45	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	6,029,400.00	4,751,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	420,804,200.00	498,604,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,804,200.00	498,604,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,851,456,418.69</b>	<b>3,955,935,963.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,851,456,418.69</b>	<b>3,955,935,963.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,775,290,410.69	3,604,536,637.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,961,049,635.00	2,445,351,472.00
210101	Үндсэн цалин	1,052,268,573.00	1,460,118,526.00
210102	Нэмэгдэл	811,658,496.00	844,039,595.00
210104	Урамшуулал	97,122,566.00	141,193,351.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	256,704,701.00	311,105,385.00
210201	Тэтгэврийн даатгал	181,428,001.00	211,654,409.32
210202	Тэтгэмжийн даатгал	18,819,200.00	24,865,168.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,055,300.00	19,903,179.96
210204	Ажилгүйдлийн даатгал	3,763,800.00	4,971,020.30
210205	Эрүүл мэндийн даатгал	37,638,400.00	49,711,606.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	393,086,643.00	415,532,900.00
210301	Гэрэл, цахилгаан	6,238,080.00	13,000,000.00
210302	Түлш, халаалт	372,032,900.00	372,032,900.00
210303	Цэвэр, бохир ус	14,815,663.00	30,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,564,961.45	17,920,943.00
210401	Бичиг хэрэг	2,459,405.45	940,000.00
210402	Тээвэр, шатахуун	650,000.00	380,000.00
210404	Ном, хэвлэл	9,089,400.00	4,751,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,475,573.00	10,459,083.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,390,660.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,994,470.00	3,013,657.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,956,300.00	3,013,657.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,771,300.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	25,771,300.00	15,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,713,210.00	12,250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	12,250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	104,305,690.24	384,362,280.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	79,971,288.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,819,280.00	50,594,951.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,486,410.24	253,796,041.13
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	76,166,008.00	351,399,326.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	68,098,400.00	351,399,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,551,900.00	252,277,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,546,500.00	99,121,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	226.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	226.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>210,220,701.10</b>	<b>258,217,614.77</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>205,958,560.17</b>	<b>258,217,614.77</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,811,426,864.45</b>	<b>3,914,428,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,206,550.00</b>	<b>51,385,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	34,206,550.00	51,385,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,206,550.00	51,385,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,206,550.00	50,050,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,335,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,777,220,314.45</b>	<b>3,863,043,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	3,358,187,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	3,358,187,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	40,566,514.45	6,251,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,787,114.45	1,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,029,400.00	4,751,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	420,804,200.00	498,604,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,804,200.00	498,604,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,784,566,164.45</b>	<b>3,722,850,221.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,784,566,164.45</b>	<b>3,722,850,221.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,708,400,156.45</b>	<b>3,371,450,895.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,961,049,635.00	2,445,351,472.00
210101	Үндсэн цалин	1,052,268,573.00	1,460,118,526.00
210102	Нэмэгдэл	811,658,496.00	844,039,595.00
210104	Урамшуулал	97,122,566.00	141,193,351.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	256,704,701.00	311,105,385.00
210201	Тэтгэврийн даатгал	181,428,001.00	211,654,409.32
210202	Тэтгэмжийн даатгал	18,819,200.00	24,865,168.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,055,300.00	19,903,179.96
210204	Ажилгүйдлийн даатгал	3,763,800.00	4,971,020.30
210205	Эрүүл мэндийн даатгал	37,638,400.00	49,711,606.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	393,086,643.00	415,532,900.00
210301	Гэрэл, цахилгаан	6,238,080.00	13,000,000.00
210302	Түлш, халаалт	372,032,900.00	372,032,900.00
210303	Цэвэр, бохир ус	14,815,663.00	30,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,543,297.45	4,751,200.00
210404	Ном, хэвлэл	15,339,400.00	4,751,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,274,800.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	25,771,300.00	15,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,713,210.00	33,095,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,705,210.00	10,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	22,595,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27,683,200.00	146,614,438.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	108,490,738.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,683,200.00	38,123,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,166,008.00</b>	<b>351,399,326.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	68,098,400.00	351,399,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,551,900.00	252,277,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,546,500.00	99,121,600.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	226.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	226.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>26,860,700.00</b>	<b>191,578,279.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>26,860,700.00</b>	<b>141,529,010.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	<b>26,860,700.00</b>	<b>141,529,010.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,860,700.00	141,529,010.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b>-26,860,700.00</b>	<b>-141,529,010.00</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	50,049,269.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	50,049,269.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,159,968,168.00	799,476,710.43	-100,775,165.43	1,858,669,713.00
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,159,968,168.00	799,476,710.43	-100,775,165.43	1,858,669,713.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,159,968,168.00	799,476,710.43	-100,775,165.43	1,858,669,713.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	300,000.00	00.00	00.00	300,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	258,217,614.77	258,217,614.77
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,160,268,168.00	799,476,710.43	157,442,449.34	2,117,187,327.77

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,409,572,500.00	3,359,523,231.00	50,049,269.00	98.53
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,409,572,500.00	3,359,523,231.00	50,049,269.00	98.53

210	Бараа, үйлчилгээний зардал	3,055,601,600.00	3,008,124,131.00	47,477,469.00	98.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,429,342,900.00	2,385,010,265.00	44,332,635.00	98.18
210101	Үндсэн цалин	1,750,265,700.00	1,412,175,351.00	338,090,349.00	80.68
210102	Нэмэгдэл	581,366,300.00	835,613,400.00	(254,247,100.00)	143.73
210104	Урамшуулал	97,710,900.00	137,221,514.00	(39,510,614.00)	140.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,668,000.00	303,374,918.00	293,082.00	99.90
210201	Тэтгэврийн даатгал	206,494,200.00	206,303,726.00	190,474.00	99.91
210202	Тэтгэмжийн даатгал	24,293,400.00	24,257,506.00	35,894.00	99.85
210203	ҮОМШӨ ний даатгал	19,434,800.00	19,417,010.00	17,790.00	99.91
210204	Ажилгүйдлийн даатгал	4,858,700.00	4,854,252.00	4,448.00	99.91
210205	Эрүүл мэндийн даатгал	48,586,900.00	48,542,424.00	44,476.00	99.91
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	35,915,800.00	33,095,500.00	2,820,300.00	92.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,500,000.00	10,500,000.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	25,415,800.00	22,595,500.00	2,820,300.00	88.90
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	286,674,900.00	286,643,448.00	31,452.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	248,551,200.00	248,519,748.00	31,452.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,123,700.00	38,123,700.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	353,970,900.00	351,399,100.00	2,571,800.00	99.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	353,970,900.00	351,399,100.00	2,571,800.00	99.27
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	254,849,300.00	252,277,500.00	2,571,800.00	98.99
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	99,121,600.00	99,121,600.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,409,572,500.00	3,409,572,500.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,358,187,500.00	3,358,187,500.00	-	100.00

131001	Улсын төсвөөс санхүүжих	3,358,187,500.00	3,358,187,500.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	51,385,000.00	51,385,000.00	-	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,050,000.00	50,050,000.00	-	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,335,000.00	1,335,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,049,269.00	(50,049,269.00)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	127.00	124.00	3.00	97.64
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	95.00	94.00	1.00	98.95
620003	Үйлчлэх ажилтан	31.00	29.00	2.00	93.55

### 2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
<b>21</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>498,604,800.00</b>	<b>498,604,574.00</b>	<b>226.00</b>	<b>100.00</b>
210	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	498,604,800.00	498,604,574.00	226.00	100.00
2101	Бараа, үйлчилгээний зардал	498,604,800.00	498,604,574.00	226.00	100.00
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,341,300.00	60,341,207.00	93.00	100.00
210102	Үндсэн цалин	47,943,200.00	47,943,175.00	25.00	100.00
210104	Нэмэгдэл	8,426,200.00	8,426,195.00	5.00	100.00
2102	Урамшуулал	3,971,900.00	3,971,837.00	63.00	100.00
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,730,600.00	7,730,467.00	133.00	100.00
210202	Тэтгэврийн даатгал	5,350,700.00	5,350,683.32	16.68	100.00
210203	Тэтгэмжийн даатгал	607,700.00	607,662.46	37.54	99.99
210204	ҮОМШӨ ний даатгал	486,200.00	486,169.96	30.04	99.99
210205	Ажилгүйдлийн даатгал	116,800.00	116,768.30	31.70	99.97
2103	Эрүүл мэндийн даатгал	1,169,200.00	1,169,182.96	17.04	100.00
210301	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	415,532,900.00	415,532,900.00	-	100.00
210302	Гэрэл цахилгаан	13,000,000.00	13,000,000.00	-	100.00
210303	Түлш, халаалт	372,032,900.00	372,032,900.00	-	100.00
2106	Цэвэр, бохир ус	30,500,000.00	30,500,000.00	-	100.00
210604	Эд хогшил худалдан авах	15,000,000.00	15,000,000.00	-	100.00
	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	-	100.00

1320	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>498,604,800.00</b>	<b>498,604,574.00</b>	<b>226.00</b>	<b>100.00</b>
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	498,604,800.00	498,604,574.00	226.00	100.00
4	Орон нутгийн төсвөөс	498,604,800.00	498,604,574.00	226.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
62	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
620001	АЖИЛЛАГСДЫН ТОО	127.00	124.00	3.00	97.64
620002	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620003	Гүйцэтгэх ажилтан	95.00	94.00	1.00	98.95
63	Үйлчлэх ажилтан	31.00	29.00	2.00	93.55

### 2.5.3 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Нэмэлт төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,251,200.00	6,251,200.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	6,251,200.00	6,251,200.00	-	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	6,251,200.00	6,251,200.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,751,200.00	4,751,200.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	4,751,200.00	4,751,200.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,251,200.00	6,251,200.00	-	100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,251,200.00	6,251,200.00	-	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,751,200.00	4,751,200.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:**  
Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Тус байгууллага 2022 онд “Эрүүл зөв дадал, эерэг хандлага, бүтээлч оролцоог хэвшүүлж сургалтын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг төлөвлөж, 93.3 хувьтай дүгнэгдсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
  - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
  - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
  - БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.

- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал “Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай”
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал “ Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу сургуулийн захирлын 2019 оны А/12 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2019-2021 онуудын тайланд нийцлийн аудит хийсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 258,517.6 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	50,049.3	(50,049.3)
Авлага	-	-	-
Бараа материал	247,147.8	310,695.1	(63,547.3)
Үндсэн хөрөнгө	1,611,521.9	1,756,442.9	(144,921.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,858,669.7</b>	<b>2,117,187.3</b>	<b>(258,517.6)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,858,669.7	2,117,187.3	(258,517.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,858,669.7</b>	<b>2,117,187.3</b>	<b>(258,517.6)</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, эздийн өмчийн, үндсэн хөрөнгө дансдууд өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 50,49.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, НДШ-ийн зардлаас хэмнэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 63,547.3 мянган төгрөгөөр өссөн нь боловсролын шинэчлэлийн хүрээнд нөхөн хангалтын зардалд сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 144,921.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан 141,529.0 мянган төгрөг, хандив болон үнэ төлбөргүй ирсэн 257,188.0 мянган

төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 253,796.0 мянган төгрөг, 37,998.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

##### **Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих зардлын дүнг 2,902,558.9 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

УИХ-аар 2022 оны төсвийг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэхээр болсонтой холбоотойгоор байгууллагын төлөвлөж хүргүүлсэн дүнг 149,199.1 мянган төгрөгөөр бууруулан 2,753,359.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр төсвийн хуваарьт дараах байдлаар өөрчлөлт оруулсан байна. Үүнд: БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаал, 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 656,212.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Ингэснээр нийт төсвийн зарлагыг 3,409,572.5 мянган төгрөгөөр, үүнээс 3,358,187.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 51,385.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан байна.

##### **Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 560,055.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Мөрөн сумын ЗДТГ-т хүргүүлснийг сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 560,055.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж, 61,450.6 мянган төгрөгөөр бууруулан, 498,604.8 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 3,409,572.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 498,604.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийт 3,908,177.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 51,385.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 51,385.0 мянган төгрөгийн төвлөрүүлж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын гүйцэтгэл 99.9 хувьтай, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 0.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн.

Улсын төсвөөс санхүүжих зардал 98.5 хувийн гүйцэтгэлтэй, зарцуулагдаагүй үлдэгдэл 50,049.3 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр байршиж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	10,166.3	10,166.3	-	100.0
2	80312-Сургалт семинар	5,083.2	5,083.2	-	100.0
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	11,691.3	11,691.3	-	100.0
4	81801-Үдийн цай хөтөлбөр	254,849.3	252,277.5	2,571.8	99.0
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	106,395.0	106,364.0	31.0	99.9
6	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	22,874.2	22,874.2	-	100.0
7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,611,433.5	2,591,766.4	19,667.1	99.2
8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	335,694.7	310,417.4	25,277.3	92.5
9	81844 – Гүнзгий сургалт	39,585.0	37,083.2	2,501.8	93.7
10	81848-түрээсийн ном	10,500.0	10,500.0	-	100.0
11	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	1,300.0	1,300.0	-	100.0
<b>Дүн</b>		<b>3,409,572.5</b>	<b>3,359,523.2</b>	<b>50,049.3</b>	<b>98.5</b>
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	430,532.9	430,532.9	-	100.0
2	80112-Нийтлэг үйлчилгээ	68,071.9	68,071.7	0.2	99.9
<b>Дүн</b>		<b>498,604.8</b>	<b>498,604.6</b>	<b>0.2</b>	<b>99.95</b>
<b>Нийт дүн</b>					

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Б.Мядагмаа гүйцэтгэж, анхан шатын хяналтыг аудитор Ц.Мөнхтуяа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,851,456.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 57,029.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан ба улсын төсвийн мэдээлэл технологийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлаас 50,049.3 мянган төгрөг хэмнэж дансны үлдэгдлээр үлдсэн, орон нутгийн төсвөөс гэрэл цахилгаан, урсгал засварын зардлаас 0.2 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Харилцах дансны үлдэгдлийн 50,049.3 мянган төгрөгийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.